



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Төсвийн сахилга, хариуцлагыг
сайжруулах зарим арга хэмжээний
тухай

Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтын 14.1.3 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын байгууллага, түншлэгч орны санхүүгийн байгууллагаас Монгол Улсын Засгийн газар Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн ашиглалтыг сайжруулах, төсөл, хөтөлбөрийн санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг төслийн захирал, зохицуулагч нарт даалгасгай.

- 1.1. Төслийн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар тогтмол ханган, хяналт тавьж ажиллах;
- 1.2. Төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагаа болон нийлүүлэгдэх бараа ажил, үйлчилгээг зохих хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулж байх;
- 1.3. Зээл тусламжийн хөрөнгийн зарцуулалтын төлбөр тооцоог тогтоосон хугацаанд нь гүйцэтгэн, хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв бүртгэн, тайлагнаж байх;
- 1.4. Төслийн үйл ажиллагааны тайлан, мэдээг “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын 8.2.6, 8.2.8, 8.2.9, 8.2.14-т заасны дагуу мэдээлж, тайлагнаж, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэст хүргүүлж байх;
- 1.5. Төслийн гадаад, дотоод эх үүсвэрээс бүрдүүлэх хөрөнгийн жагсаалтыг жил бүрийн 2 дугаар сард Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэст урьдчилан танилцуулж байх;

D:\barimt\tushaal

080110

- 1.6. Зээл тусламжийн хөрөнгийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулах зайлшгүй шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөр хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулан, баталгаажуулж байх;
- 1.7. Төслийн хэрэгжилтийг шуурхай хангаж, түүний гүйцэтгэлийг удаашруулахгүй байх бүхий л нөхцлийг бүрдүүлж санаачилгатай ажиллах;
- 1.8. Төслийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахгүй байх;
- 1.9. Төслийн үйл ажиллагаанд Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”, 2014 оны “Засгийн газрын гадаад зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журамд өөрчлөлт оруулах тухай 160 дугаар тушаалын холбогдох заалтуудыг тус тус хэрэгжүүлж, түүний биелэлтийг жил бүрийн 7 дугаар сарын 1, 12 дугаар сарын 30-ны дотор Стратегийн бодлого, төлөвлөлтийн газарт ирүүлж байх;
- 1.10. Гадаад зээл тусламжийн төсөл хөтөлбөрийн хүрээнд зарцуулж байгаа санхүүгийн зардлын мэдээ, тайланг Шилэн дансны тухай хуулийн дагуу нийтэд мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулж байх;

2. Гадаад зээл тусламжийн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, дүнг 2015 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Хяналт- шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Гадаад зээл, тусламжийн хөрөнгийг захиран зарцуулах журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчиж, төслийн санхүүгийн сахилга бат алдагдуулсан төслийн захирал, зохицуулагч, нягтлан бодогч бусад албан тушаалтнуудад хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага тооцон, хөлсөөр ажиллах гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-т даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар/Б.Эрдэнэчимэг/-т даалгасугай.

САЙД  Г.ШИЙЛЭГДАМБА